

**АКАДЕМИК ОРЧНЫ ЁС ЗҮЙ НИЙГМИЙН ИННОВАЦИЙН СУУРЬ
ҮНДЭС БОЛОХ НЬ**

Э. Энхцолмон

Докторант

Нийгэм, хүмүүнлэгийн сургууль

Шинжлэх ухаан, технологийн их сургууль

☎ 0009-0007-0312-143X

DOI: 10.66753/

e.tsootoo29@gmail.com

Ц. Батцэрэн

Доктор (Ph. D.), дэд профессор

Нийгэм, хүмүүнлэгийн сургууль

Шинжлэх ухаан, технологийн их сургууль

☎ 0009-0001-3297-2002

DOI: 10.66753/

tseren_mn@must.edu.mn

Хураангуй: Өнөө үед нийгмийн инновацийг зөвхөн тухайн улсын хөгжил дэвшил, нийгмийн шинэчлэлийн асуудал гэж авч үзэхээс гадна, ёс зүйд тулгуурласан мэдлэгийн хэрэглээний хэлбэр гэж тайлбарлах хандлага нэмэгдэж байна. Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага нийгмийн инновацийг нийтийн сайн сайхан байдлыг дээшлүүлэхэд чиглэсэн шинэ шийдэл гэж тодорхойлдог бол ЮНЕСКО дээд боловсролын байгууллагыг нийгмийн хөгжил, инновацийн чухал институт гэж тодорхойлсон байдаг. Энэхүү өгүүллийн зорилго нь академик орчны ёс зүй нь нийгмийн инновацийн суурь үндэс болохыг онолын түвшинд тайлбарлаж, дээд боловсролын салбарт хэрэгжүүлэх боломжит практик ач холбогдлыг тодорхойлоход оршино. Өгүүлэлд баримт бичгийн шинжилгээ, ойлголтын харьцуулсан аргуудыг ашиглан олон улсын эрх зүй, ёс зүйн баримт бичиг болон үзэл баримтлалуудыг нэгтгэн шинжилсэн болно. Судалгааны үр дүнд академик орчны ёс зүй нь нийгмийн инновацийн агуулга, хэрэгжилтийн арга, үр нөлөөний үнэлгээ, нийгмийн хариуцлагыг тодорхойлох суурь хүчин зүйл гэдэг нь харагдаж байна. **Түлхүүр үг:** Ёс зүй, академик иударга байдал, дээд боловсрол, нийгмийн хариуцлага, импликаци

УДИРТГАЛ

Академик орчны ёс зүйг дээд боловсрол, судалгаа, эрдэм шинжилгээний хүрээнд мэдлэг бүтээх, түгээх, үнэлэх, хэрэглэх үйл явцад мөрдөх үнэт зүйл, зарчмын тогтолцоо хэмээн ойлгож ирсэн. Үүнд үнэнч шударга байдал, хариуцлага, ил тод байдал, хүндэтгэл, тэгш оролцоо зэрэг суурь үнэт зүйлс багтдаг. Шинжлэх ухааны хөгжил хурдацтайгаар өсөн нэмэгдэхийн зэрэгцээ их, дээд сургууль, судалгааны байгууллагын үүрэг улам

ихээр өргөжин тэлж, эдгээрийг зөвхөн мэдлэг дамжуулах байгууллага бус, харин нийгмийн өөрчлөлт, тогтвортой хөгжил, инновацийн чухал оролцогч гэж үзэх болсон. ЮНЕСКО дээд боловсролыг мэдлэг, судалгаа, инновацийн солилцоог дэмжих, нийгмийн хөгжилд хувь нэмэр оруулах чухал орон зай гэж тодорхойлж, их сургуулийг эдийн засаг, нийгэм, соёлын ахицын хөдөлгөгч хүч гэж үздэг.

“Нийгмийн инноваци” нь нийгмийн тулгамдсан асуудлыг шийдвэрлэх, нийгмийн сайн сайхан байдлыг дээшлүүлэх, хүртээмж ба хамтын оролцоог нэмэгдүүлэх зорилготой шинэ санаа, үйл явц, үйлчилгээ, зохион байгуулалт бүхий шийдлийг хамарсан өргөн хүрээний ойлголт юм. Энэ хүрээнд ЭЗХАХБ¹ нийгмийн инновацийг хувь хүн, хамт олон, нийгмийн сайн сайхан байдлыг сайжруулахад чиглэсэн шинэ шийдэл хэмээн тодорхойлж, нийгмийн үнэ цэнэ, оролцоо, бодит хэрэгцээг төвд нь тавих шаардлагатайг онцолдог.

Энэхүү нөхцөлд академик орчин нь нийгмийн инновацийн эх үүсвэр, туршилтын талбар, нотолгоонд суурилсан шийдэл боловсруулах чухал орон зай болж байна. Гэвч нийгмийн инноваци нь зөвхөн “шинэлэг” байх төдий хангалтгүй бөгөөд үнэн зөв мэдлэгт тулгуурласан, оролцогч талуудын эрх ашгийг хүндэтгэсэн, ил тод, хариуцлагатай байх шаардлагатай. Иймээс нийгмийн инновацийн чанар, тогтвортой байдал нь академик орчны ёс зүйтэй салшгүй холбоотой юм.

Академик орчны ёс зүй нь “Академик ёс зүй”, “Академик шударга байдал” ойлголтуудтай салшгүй холбоотой ба сургалт, судалгаа, эрдэм шинжилгээ, үнэлгээ, хамтын ажиллагааны хүрээнд мөрдөх ёс суртахууны зарчим, үнэт зүйл, хэм хэмжээний тогтолцоо юм. Тухайлбал, “Академик шударга байдлын олон улсын төв”² (ICAI) нь академик орчинд шударга, ёс зүйтэй соёлыг төлөвшүүлэхэд чиглэж, *үнэнч байдал, итгэлцэл, шударга ёс, хүндэтгэл, хариуцлага, эр зориг* гэсэн зургаан үндсэн үнэт зүйлийг тодорхойлсон. Европ тивийн хэмжээнд академик шударга байдлыг хөгжүүлэх, хамгаалах, түгээх зорилготой сүлжээ байгууллага болох “Академик шударга байдлын Европын сүлжээ”³ (ENAI) нь дээд боловсролын байгууллагуудыг академик шударга байдлын чиглэлээр хамтран ажиллахад дэмжих, сургалт, судалгаа, хэвлэн нийтлэлт, институцийн бодлого, ёс зүйн орчныг бүхэлд нь

¹ ЭЗХАХБ-Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага. 1961 онд байгуулагдсан улс 100 гаруй улс орнуудын засгийн газарт зөвөлгөө өгдөг олон улсын байгууллага. Organisation for Economic Co-operation and Development - OECD

² Академик шударга байдлын олон улсын төв-АШБОУТ буюу International Center for Academic Integrity (ICAI) нь 1992 онд байгуулагдсан дэлхий дахинаа академик хамт олонд чиглэсэн үйл ажиллагаа явуулдаг ашгийн төлөө бус олон улсын байгууллага.

³ Академик шударга байдлын Европын сүлжээ- АШБЕС буюу European Network for Academic Integrity (ENAI) нь 2017 онд байгуулагдсан Европын хэмжээнд академик шударга байдлыг хөгжүүлэх, хамгаалах, түгээх зорилготой үйл ажиллагаагаа явуулдаг сүлжээ байгууллага юм.

сайжруулах чиглэлд голлон ажиллахын сацуу “академик ёс зүй”-г боловсрол, судалгаа, эрдэм шинжилгээний хүрээнд шийдвэр гаргалтыг чиглүүлэх мэргэжлийн болон ёс зүйн зарчим гэж тайлбарладаг. Гэсэн хэдий ч академик орчны ёс зүй болон нийгмийн инновацийн харилцан хамаарлыг системтэйгээр онолын түвшинд авч үзсэн судалгаа харьцангуй хомс байна.

Иймээс энэхүү өгүүлэл дараах үндсэн асуултад хариулахыг зорьж байна. Үүнд:

1. Нийгмийн инновацийн ойлголт, үндсэн шинжүүд юу болох,
2. Академик орчин ба ёс зүй ямар утгатай болох тухай,
3. Яагаад академик орчны ёс зүйг нийгмийн инновацийн суурь үндэс гэж үзэх ёстой вэ?

Эдгээр асуултад хариулах нь дээд боловсролын байгууллагын нийгмийн хариуцлага, судалгааны шударга байдал, инновацийн бодлогын үнэт зүйлсийн суурийг онол, парктикийн түвшинд илүү тодорхой болгох ач холбогдолтой.

АРГА ЗҮЙ

Энэхүү өгүүлэл нь чанарын судалгааны хүрээнд баримт бичгийн шинжилгээ(document analysis)-нд тулгуурласан онолын судалгаа болно. Судалгаанд нийгмийн инноваци, дээд боловсрол, академик шударга байдал, академик ёс зүйтэй холбоотой олон бодлогын баримт бичиг, тайлан, үзэл баримтлалын эх сурвалжуудыг сонгон авч шинжилсэн. Үндсэн эх сурвалжид ЭЗХАХБ (OECD)-ын нийгмийн инновацийн талаархи холбогдох тайлан, ЮНЕСКО (UNESCO)-гийн дээд боловсролын бодлогын материалууд (2024 ба 2025 он), Академик шударга байдлын олон улсын төв (International Center for Academic Integrity)-ийн Академик шударга байдлын олон улсын төв (The Fundamental Values of Academic Integrity, ICAI), Европын академик шударга байдлын сүлжээ (European Network for Academic Integrity, ENAI)-ийн тодорхойлолт, удирдамжууд багтсан болно.

Арга зүйн хувьд дараах гурван үе шаттайгаар гүйцэтгэсэн.

Нэгдүгээрт, “нийгмийн инноваци”, “академик орчин”, “академик ёс зүй”, “академик шударга байдал” гэсэн суурь ойлголтуудын тодорхойлолт, нийтлэг шинж, үнэт зүйлсийн агуулгыг эх сурвалж тус бүрээс ялган авч, ойлголтын түвшинд ангилан системчилсэн.

Хоёрдугаарт, эдгээр ойлголтын хоорондын уялдаа холбоог харьцуулсан агуулгын шинжилгээ(comparative content analysis) -ний аргаар задлан шинжилсэн.

Гуравдугаарт, академик орчны ёс зүй нь нийгмийн инновацийн суурь үндэс болох тухай нэгтгэсэн онолын тайлбарыг боловсруулж, ойлголтуудын харилцан хамаарлын загварчилсан тайлбарыг дэвшүүлсэн.

Энэхүү арга зүй нь эмпирик тоон өгөгдөл ашиглаагүй боловч олон эх сурвалжид тулгуурласан ойлголтын уялдаа, онолын үндэслэлийг системтэйгээр тайлбарлах боломжийг бүрдүүлж байна.

Мөн энэхүү судалгаа нь практик кейс, ярилцлага, асуулга, статистик өгөгдөл ашиглаагүй тул дүгнэлт нь эмпирик баталгаа бус, харин олон улсын эрх бүхий байгууллагын үзэл баримтлалд тулгуурласан концепцийн нэгтгэл болно. Гэсэн хэдий ч уг онолын судалгаа нь цаашдын эмпирик судалгааны чиглэл, үнэлгээний шалгуурыг тодорхойлоход суурь хүрээ (framework) болж ашиглагдах боломжтой гэж үзэж байна.

ҮР ДҮН БА ХЭЛЭЛЦҮҮЛЭГ

3.1. Нийгмийн инновацийн мөн чанар

Нийгмийн инновацийг нийгмийн асуудалд илүү үр дүнтэй, тогтвортой, шударга хариу өгөх шинэ санаа, үйл явц, үйлчилгээ, зохион байгуулалтын шийдэл хэмээн тодорхойлдог. Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагын (ЭЗХАХБ) тайлбар ёсоор нийгмийн инноваци нь зөвхөн шинэ байх төдий бус, нийгмийн сайн сайхан байдлыг дээшлүүлэх, бодит хэрэгцээг хангах, олон оролцогчийн хамтын ажиллагаанд тулгуурлах ёстой. Түүнчлэн нийгмийн инноваци нь зорилго болон хэрэгжих арга хэлбэр аль алинаараа “нийгмийн” шинжтэй байх бөгөөд энэ нь түүнийг цэвэр технологийн инновациас ялгаж өгдөг. Технологийн инноваци зах зээлийн үр ашиг, бүтээмжид түлхүү чиглэдэг бол нийгмийн инноваци нь тэгш байдал, хүртээмж, оролцоо, хамтын сайн сайхныг чухалчилдаг.

Иймээс нийгмийн инновацийн үнэлгээ нь зөвхөн эдийн засгийн өгөөжөөр хязгаарлагдах боломжгүй харин нийгмийн нөлөө, түүнд оролцогч талуудын оролцоо, шударга байдал, хүртээмж, тогтвортой байдал зэрэг хэмжигдэхүүнийг хамтад нь авч үзэх шаардлагатай. Энэ утгаараа нийгмийн инноваци нь ёс зүйн үнэлгээ шаарддаг ойлголт болохыг илтгэнэ. Учир нь нийгмийн инноваци нь хүний сайн сайхан байдал, нөөцийн хуваарилалт, оролцооны шударга байдлыг шууд хөнддөг тул ёс зүйн үнэлгээ зайлшгүй шаарддаг.

3.2. Академик орчин нийгмийн инновацийн институцийн талбар болох нь

Академик орчин бол мэдлэг бүтээх, түгээх, шүүн тунгаах, турших, хэрэглээнд нэвтрүүлэх институцийн орон зай юм. ЮНЕСКО-ийн үзэл баримтлалаар дээд боловсролын байгууллагууд нь зөвхөн сургалтын бүтэц төдий бус, нийгэм, эдийн засаг, соёлын хөгжилд хувь нэмэр оруулах мэдлэгийн зангилаа бүхий томоохон институци бөгөөд энэ утгаараа академик орчин

нийгмийн инновацийн хувьд дараах үндсэн үүргүүдийг гүйцэтгэдэг гэж үзэж болно.

- Нэгдүгээрт, нийгмийн асуудлыг оношлох шинжлэх ухааны чадамжийг бүрдүүлнэ.
- Хоёрдугаарт, шинэ шийдлийг турших арга зүй, судалгааны орчныг бүрдүүлнэ.
- Гуравдугаарт, төр, иргэний нийгэм, бизнес, орон нутгийн хамтын ажиллагааг холбох зуучлагч орон зай болно.
- Дөрөвдүгээрт, нийгмийн инновацийг хөгжүүлэх хүний нөөц, ур чадвар, шүүмжлэлт сэтгэлгээг төлөвшүүлнэ.

Иймээс академик орчин нь нийгмийн инновацийн санамсаргүй биш, харин институцийн хувьд чухал эх сурвалж юм. Гэвч мэдлэг бүтээх бүх орчин автоматаар нийгмийн хариуцлагатай инноваци төрүүлдэггүй харин нийгмийн хариуцлагатай инноваци бий болох эсэхийг тодорхойлох гол хүчин зүйл нь академик орчны ёс зүйн түвшин юм.

3.3. Академик орчны ёс зүй ба академик шударга байдлын суурь үнэт зүйлс

Академик орчны ёс зүй нь академик шударга байдалтай нягт холбоотой. Академик шударга байдлын олон улсын төвийн (ICAI) тодорхойлсон зургаан үнэт зүйл болох үнэнч шударга байдал, итгэлцэл, шударга ёс, хүндэтгэл, хариуцлага, эр зориг нь зөвхөн оюутны хуулахгүй байх асуудлыг илэрхийлэхгүй, харин мэдлэг бүтээх, хамтран ажиллах, үнэлэх, шийдвэр гаргах бүх үйл явцын ёс зүйн суурь юм. Мөн Академик шударга байдлын Европын сүлжээ болох (ENAI) нь академик шударга байдлыг мэргэжлийн болон ёс зүйн хэм хэмжээг сахих институцийн соёл гэж үздэг. Иймээс академик орчны ёс зүй нь хувь хүний зан суртахууны асуудал төдийгүй байгууллагын бодлого, үнэлгээний механизм, удирдлагын шийдвэр, хамтын ажиллагааны бүтэцтэй холбоотой. Энэ логикоор авч үзвэл нийгмийн инноваци академик орчноос төрөхдөө дараах ёс зүйн шаардлагыг хангах ёстой. Үүнд:

- асуудлыг зөв тодорхойлохын тулд үнэн зөв өгөгдөл, нотолгоо ашиглах;
 - оролцогч талуудын дуу хоолойг хүндэтгэх;
 - эмзэг бүлэг, тэгш бус байдлыг үл орхигдуулах;
 - үр нөлөөг хэтрүүлэлгүй үнэлэх;
 - ашиг сонирхлын зөрчлийг ил тод зохицуулах;
 - үр дүнг нийгмийн сайн сайханд чиглүүлэх.
- Эдгээр нь бүгд академик орчны ёс зүйн агуулга мөн.

3.4. Академик орчны ёс зүй нийгмийн инновацийн суурь үндэс болох нь

Академик орчны ёс зүйг нийгмийн инновацийн суурь үндэс гэж үзэх шалтгааныг дараахи гурван түвшинд тайлбарлахыг оролдлоо. Үүнд:

1. *Танин мэдэхүйн суурь болох нь*: Мэдлэгийн үнэн зөв байдал нь нийгмийн инновацийн эхний бөгөөд хамгийн чухал суурь үндэс нь юм. Энэ утгаараа нийгмийн инноваци нь бодит нийгмийн асуудлыг зөв таних, шалтгааныг нь оновчтой тайлбарлах, үр дүнтэй шийдэл боловсруулахыг шаарддаг. Хэрэв академик орчинд өгөгдөл гуйвуулах, судалгааны үр дүнг хэтрүүлэх, эх сурвалжийг буруу ашиглах, дүгнэлтийг урьдчилан тохируулах зэрэг ёс зүйн зөрчил түгээмэл байвал инновацийн нэрээр буруу шийдэл төрөх эрсдэл нэмэгдэнэ.

2. *Нийгмийн суурь болох нь*: Нийгмийн инноваци нь олон оролцогчийн хамтын ажиллагаанд тулгуурладаг. Энэ хамтын ажиллагаанд иргэд, орон нутгийн хүмүүс, төрийн байгууллага, бизнес, иргэний нийгэм, судлаачид зэрэг олон тал оролцдог. Хэрэв академик орчинд хүндэтгэл, тэгш оролцоо, шударга харилцаа төлөвшөөгүй бол нийгмийн инноваци нь бодит хамтын ажиллагаа бус, нэг талын шийдэл болж хувирах эрсдэлтэй. Тиймээс академик ёс зүй нь инновацийн оролцооны чанарыг тодорхойлдог.

3. *Институцийн суурь болох нь*: Нийгмийн инноваци нь зөвхөн нэг удаагийн санаачилга байхаас илүү тогтвортой хэрэгжиж өргөжих, итгэлцэл бий болгох зайлшгүй шаардлагатай. Үүнийг хангахын тулд байгууллагын түвшинд ил тод байдал, хариуцлага, ёс зүйн зохицуулалт, шударга үнэлгээний соёл хэрэгтэй. Ийм институцийн үндэсгүй инноваци богино хугацаанд “шинэ” мэт харагдавч урт хугацаанд итгэлцэл алдах, буруу бодлого тогтох, нийгмийн тэгш бус байдлыг нэмэгдүүлэх зэрэг эрсдэлүүдийг бий болгох сөрөг талтай.

Эдгээр гурван түвшин нь академик орчны ёс зүй нийгмийн инновацид хэрхэн нөлөөлдөг онолын хүрээг илэрхийлж байна.

3.5. Академик орчин дахь ёс зүйгүй байдал нь нийгмийн инновацийн эрсдэл болох нь

Академик орчны ёс зүйн хямрал нь нийгмийн инновацид хэд хэдэн сөрөг үр дагавар үүсгэж болно. Үүнд:

Нэгдүгээрт, буруу дата өгөгдөл, хангалтгүй судалгаанд тулгуурласан шийдэл нийгмийн бодит асуудлыг улам хүндрүүлэх эрсдэлтэй.

Хоёрдугаарт, оролцогч талуудын эрх ашиг, дуу хоолойг үл тоомсорловол инноваци нэртэй боловч нийгмийн хувьд шударга бус, хүчтэй талд ашигтай шийдэл болж болзошгүй.

Гуравдугаарт, ил тод бус, ашиг сонирхлын зөрчилтэй орчинд хэрэгжсэн инноваци олон нийтийн итгэлцлийг алддаг. Иймээс академик ёс зүй нь нийгмийн инновацийн чанарыг зөвхөн сайжруулаад зогсохгүй, буруу инновациас урьдчилан сэргийлэх хамгаалалтын механизм болдог.

3.6. Дээд боловсролын байгууллагад өгөх онолын ба практик импликаци

Сүүлийн үед “инноваци” хэмээх ойлголт өргөнөөр хэрэглэгдэх болсон ч ихэнхи тохиолдолд зөвхөн шинэлэг, оновчтой, ашигтай байдлаар төсөөлж, богино хугацааны аргацаасан шийдлүүдийг хэрэгжүүлэх замаар төсөл хөтөлбөрүүдийг олон удаа хэрэгжүүлэх нь түгээмэл байжээ. Үүний үр дүнд нийгэмд үзүүлэх ач холбогдол, урт хугацааны үр ашиг нь хангалтгүй, хөрөнгө оруулалт үр ашигтай зарцуулагдаагүй байх нь олон нийтийн нөхцөл байдлаас харагдаж байна. Энэ нь нийгмийн инновацийг зөвхөн эдийн засгийн үр ашигтай холбож, академик орчин болон академик ёс зүйтэй уялдуулахгүйгээр богино хугацааны ашиг олох гэсэн хандлагаар хэрэгжүүлж ирсэнтэй холбоотой юм.

Иймд нийгмийн инновацийн суурь нь академик орчны ёс зүйтэй холбогдсоноор шинээр хэрэгжүүлэх инноваци нь урт хугацаанд нийгмийн сайн сайхны төлөө илүү үр ашигтай, тогтвортой хэрэгжих боломжтой болно.

Энэхүү судалгааны онолын импликаци нь:

1. Академик орчны ёс зүй ба нийгмийн инновацийн уялдаа холбоог онолын түвшинд тайлбарлахад чиглэсэн.

2. Урьд өмнө академик ёс зүйг зөвхөн сургалт, судалгааны дотоод хэм хэмжээ, академик шударга байдлын хүрээнд авч үздэг байсан бол, судалгаагаар академик ёс зүйг илүү өргөн хүрээнд тайлбарлаж, нийгмийн үнэ цэнэ бүтээх, нийтийн сайн сайхныг дэмжих, мэдлэгийг хариуцлагатайгаар хэрэглэх институцийн суурь нөхцөл гэж үзсэн.

3. Академик орчны ёс зүй нь зөвхөн академик үйл ажиллагааны чанар, үнэн зөв байдлыг хангах хэрэгсэл бус, харин нийгмийн инноваци үүсэх, хөгжих, хэрэгжих үйл явцын үндэс болохыг тодруулсан.

Энэ утгаараа судалгаа нь академик ёс зүй, нийгмийн инноваци, дээд боловсролын нийгмийн үүргийн талаарх онолын хүрээг өргөжүүлж, эдгээр ойлголтыг салангид бус, нэгдмэл аналитик хүрээнд авч үзэх боломжийг бүрдүүлдэг.

Судалгааны практик импликаци, ач холбогдол нь дээд боловсролын байгууллага, судалгааны хүрээлэн, академик удирдлагын түвшинд академик орчны ёс зүйг нийгмийн инновацийн чанар, үр нөлөөг тодорхойлох бодит хүчин зүйл болгон авч үзэх шаардлагыг харуулж байна. Үүнд:

- Нийгмийн инновацийг дэмжих бодлого, хөтөлбөр, төсөл, хамтын ажиллагааны санаачилгуудыг зөвхөн шинэлэг байдал, хэрэгжилтийн хурд, гаднах үр дүн-гээр үнэлэх нь хангалтгүй.

- Академик шударга байдал, ил тод байдал, хариуцлага, оролцогч талуудын эрх ашгийг хүндэтгэх зарчим, ашиг сонирхлын зөрчлийн зохицуулалт зэрэг ёс зүйн шалгуурыг хамтад нь үнэлэх шаардлагатай.

Ингэснээр их, дээд сургуулиуд академик ёс зүйн сургалт, судалгааны ёс зүйн хяналт, инновацийн төслийн үнэлгээний шалгуур, хамтын ажиллагааны ил тод байдлыг сайжруулах бодит арга хэмжээ авах боломжтой болно.

Институцийн түвшний анхаарах зүйлс. Дээд боловсролын байгууллага нийгмийн инновацийг дэмжихдээ зөвхөн:

- төслийн санхүүжилт,
- гарааны хөтөлбөр,
- стартапын тоо,
- үйлчилгээний шинэчлэл зэрэг үзүүлэлтээр хэмжиж ирсэн нь хангалтгүй.

Харин энэхүү судалгаанаас харахад:

- Судалгааны шударга байдлын бодлого
- Ашиг сонирхлын зөрчлийн зохицуулалт
- Оролцогч талуудын хамтын шийдвэр гаргалт
- Нийгмийн үр нөлөөний үнэлгээ
- Эмзэг бүлгийн эрх, хүртээмжийг хамгаалах механизм
- Инновацийн ёс зүйн шалгуур гэсэн үзүүлэлтүүдийг хамтад нь авч

үзэх шаардлагатай. Ингэснээр нийгмийн инновацийг академик орчинд зөвхөн “төсөл” бус, “ёс зүйд суурилсан институцийн чадамж” болгон харах боломжтой. ЮНЕСКО болон ЭЗХАХБ-ийн үзэл баримтлал нь дээд боловсрол, нийгмийн инноваци, олон нийтийн сайн сайхны уялдаа холбоог ийм өргөн хүрээнд авч үздэг.

ДҮГНЭЛТ

Энэхүү өгүүлэлд нийгмийн инноваци, академик орчин, академик орчны ёс зүй гэсэн ойлголтуудыг онолын түвшинд уялдуулан авч үзэв.

- Нийгмийн инноваци нь нийгмийн асуудлыг шийдвэрлэх шинэ санаа, үйл явц, үйлчилгээ, зохион байгуулалтын шийдэл юм. Гэвч бодит үнэ цэнэ нь зөвхөн шинэлэг байдлаас гадна нийгмийн хариуцлага, шударга байдал, нотолгоонд суурилсан байдал, тогтвортой үр нөлөө зэрэг үзүүлэлтээр тодорхойлогдоно.

- Академик орчин нь ийм инноваци үүсч, туршигдаж, түгж, үнэлэгдэх институцийн талбар болдог.

- Академик орчны ёс зүй нь инновацийн үйл явцад үнэн зөв байдал, оролцооны чанар, институцийн итгэлцэл, нийгмийн хариуцлага зэрэг суурь нөхцлийг баталгаажуулдаг.

Иймээс академик орчны ёс зүйг нийгмийн инновацийн дагалдах нөхцөл биш, харин түүнийг бий болгох, хөгжүүлэх, нийгэмд хариуцлагатайгаар нутагшуулах үндсэн урьдчилсан нөхцөл гэж үзэх нь онолын болон практикийн хувьд үндэслэлтэй юм. Цаашид энэхүү онолын үндэслэлийг их, дээд сургуулийн бодит кейс, инновацийн төвүүд, оюутан-судлаачдын хамтын төслүүд, нийгмийн нөлөөллийн үнэлгээний арга зүйтэй холбон эмпирик түвшинд баталгаажуулах шаардлагатай.

НОМ ЗҮЙ

1. *International Center for Academic Integrity. (2021). The Fundamental Values of Academic Integrity (3rd ed.). https://academicintegrity.org/aws/ICAI/asset_manager/get_file/911282?ver=1*

2. *International Center for Academic Integrity. (n.d.). Values. <https://academicintegrity.org/aws/ICAI/pt/sp/values>*

3. *OECD. (2024). Assessing the framework conditions for social innovation in rural areas. OECD Publishing. https://www.oecd.org/en/publications/assessing-the-framework-conditions-for-social-innovation-in-rural-areas_74367d76-en.html*

4. *OECD. (2025). Starting, Scaling and Sustaining Social Innovation: Evidence and Impact of the European Social Fund. OECD Publishing. https://www.oecd.org/en/publications/starting-scaling-and-sustaining-social-innovation_ec1d7b67-en.html*

5. *OECD. (n.d.). Social economy and social innovation. <https://www.oecd.org/en/topics/social-economy-and-social-innovation.html>*

6. *UNESCO. (n.d.). Higher education. <https://www.unesco.org/en/higher-education>*

7. *UNESCO. (2025). What you need to know about higher education. <https://www.unesco.org/en/higher-education/need-know>*

8. *European Network for Academic Integrity. (n.d.). (2022). Academic Integrity. <https://www.academicintegrity.eu/wp/about-enai/>*

9. *European Network for Academic Integrity. (2019). General Guidelines for Academic Integrity*

10.

https://academicintegrity.eu/wp/wpcontent/uploads/2022/04/Guidelines_amended_version_1.1_09_2019.pdf